



МОНГОЛБАНКНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2019 оны 11 сарын 14 өдөр

Дугаар 8-677

Улаанбаатар хот

Б.Анхцэцэг, Б.Гэрэлмаа нарыг сургалтад
оролцуулах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1, 28.1.11 дэх заалт, “Монголбанкны сургалтын журам”-ын 3.1, 3.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Судалгаа, статистикийн газрын Статистикийн хэлтсийн эдийн засагч Б.Анхцэцэг, Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газрын Санхүүгийн зах зээлийн хэлтсийн эдийн засагч Б.Гэрэлмаа нарыг 2019 оны 11 дүгээр сарын 16-наас 23-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Солонгос Улсын Сөүл хотноо зохион байгуулагдах “Банкны шинжилгээ болон хяналт” сэдэвт сургалтад оролцуулсугай.

2. Дээрх нэр бүхий ажилтнуудын ирэх, очих онгоцны тийз болон холбогдох бусад зардлыг урьдчилгаагаар олгож, баримтыг нь үндэслэн Зүүн Өмнөд Азийн Төв Банкуудын Холбооны итгэлцлийн сангийн зардлаас эргэж тооцоо хийхийг Тамгын газар (Ж.Батхуяг), Тайлан бүртгэлийн газар (Ц.Гарьд)-т тус тус зөвшөөрсүгэй.

3. Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитын газар (Т.Амарсайхан)-т үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ



Н.БАЯРТСАЙХАН